



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/014/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

**Санхүү-нийцлийн газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**

Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхбаатар

Утас: 51-260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ

Утас: 51-261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn

Аудитор: П.Ариунзаяа

Утас: 51-261628 Цахим хаяг: Ariunzayap@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ДАРГА Я.ЭРДЭНЭСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 07/1139
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн санхүүжилтийг 11,393.5 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн, шууд зээлийн 134 зээлдэгчийн 19,442.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй, Зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой хөрөнгийг эргэлтэд оруулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.3, 41.2.7; Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0325 SNAG-22.Docx

1525071507

Асуудлыг онцолсон хэсэг

Жижиг дунд үйлдвэрийн газрын даргын 2024 оны А/15 болон А/232 дугаар тушаалаар фискус зээлийн программ болон санхүүгийн бүртгэлийн программын хооронд зөрүүтэй бүртгэгдсэн зээлдэгчийн авлагын үлдэгдлийг санхүүгийн программд тохируулсан байна.

Аудитын гол асуудал

Шууд зээлийн авлагын үлдэгдэл 99,373.3 сая төгрөгөөс тайлант хугацаанд 4,922.0 сая төгрөгийн авлагыг барагдуулж, оны эцэст шууд зээлийн 52.0 хувь буюу 96,500.7 сая төгрөгийн 360 зээлдэгчээс авах авлага "муу зээл"-ийн ангилалд бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2024 оны 38 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулан, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Төвийг бүсийг "Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс"-ээр тогтоосон байна.

Засгийн газрын 2024 оны 32 дугаар хуралдааны тэмдэглэлээр "Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн, үйлдвэрийн яам болон харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх" шийдвэрийн дагуу Жижиг, дунд үйлдвэрийн газар Дархан-Уул аймгийн Дархан суманд шилжин суурьшиж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолоор тус газрын даргад "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, оролцогчдыг уялдаа, зохион байгуулалтаар хангаж ажиллах чиг үүргийг" хариуцуулсан байна. Тус арга хэмжээний хүрээнд тайлант онд 8,971 хоршоо шинээр байгуулагдаж, хоршооны 20,325 гишүүнд 687,021.1 сая төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *B. А. Ц* ЦИХРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	272,416,457,000.98	274,652,249,238.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	15,287,745,734.48
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	15,287,745,734.48
31210	Төгрөг	-	15,287,745,734.48
31211	Төрийн сангийн харилцах	-	15,287,745,734.48
33	АВЛАГА	271,621,199,050.98	237,374,198,387.94
33300	Татаас, санхүүжилтийн авлага	16,296,420,298.19	-
33500	Бусад авлага	573,858,829.54	528,090,311.46
33510	Байгууллагаас авах авлага	339,876,642.54	302,608,178.13
33520	Хувь хүмүүсээс авах авлага	233,982,187.00	225,482,133.33
33600	Зээлийн авлага	254,750,919,923.25	236,846,108,076.48
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	254,750,919,923.25	236,846,108,076.48
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	254,750,919,923.25	236,846,108,076.48
35	БАРАА МАТЕРИАЛ	795,257,950.00	78,500,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	94,200,000.00	78,500,000.00
35400	Хангамжийн материал	701,057,950.00	-
35470	Бусад хангамжийн материал	701,057,950.00	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	21,911,805,116.41
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	-	21,911,805,116.41
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	272,416,457,000.98	274,652,249,238.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,546,803,790.13	22,582,049,888.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	612,371,554.15	470,720,388.05
41300	Өглөг	406,694,666.00	244,694,666.00
41360	Бусад өглөг	406,694,666.00	244,694,666.00
41361	Байгууллагад төлөх өглөг	406,694,666.00	244,694,666.00
41400	Урьдчилж орсон орлого	205,676,888.15	226,025,722.05
41440	Бусад урьдчилж орсон орлого	205,676,888.15	226,025,722.05
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,934,432,235.98	22,111,329,500.00
42200	Урт хугацаат зээл	16,934,432,235.98	22,111,329,500.00
42210	Төгрөг	16,934,432,235.98	22,111,329,500.00
42217	Санхүүгийн бусад байгууллага	16,934,432,235.98	22,111,329,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	254,869,653,210.85	252,070,199,350.78
51	Засгийн газрын хувь оролцоо	254,869,653,210.85	252,070,199,350.78
51200	Хуримтлагдсан үр дүн	254,869,653,210.85	252,070,199,350.78
51210	Өмнөх үеийн үр дүн	251,077,416,131.20	250,566,975,876.76
51220	Тайлант үеийн үр дүн	3,792,237,079.65	1,503,223,474.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	272,416,457,000.98	274,652,249,238.83

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,269,982,794.14	4,235,690,249.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,269,982,794.14	2,772,718,249.13
120	Нийтлэг татварын бус орлого	6,269,982,794.14	2,772,718,249.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,269,982,794.14	2,772,718,249.13
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,130,364,680.51	58,200,592.82
1200046	Зээлийн хүүгийн орлого	2,139,618,113.63	2,714,517,656.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	1,462,972,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,462,972,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,462,972,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,477,745,714.49	2,536,215,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,477,745,714.49	2,536,215,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,438,517,579.38	2,536,215,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,438,517,579.38	2,536,215,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,438,517,579.38	2,536,215,800.00
211	ХҮҮ	39,228,135.11	-
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	39,228,135.11	-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	39,228,135.11	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,792,237,079.65	1,699,474,449.13
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	196,250,975.11
230001	Эргэж төлөгдөх зээл	-	196,250,975.11
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,792,237,079.65	1,503,223,474.02

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	51,925,229,441.30	54,774,641,685.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,925,229,441.30	53,311,669,685.57
120	Нийтлэг татварын бус орлого	51,925,229,441.30	53,311,669,685.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51,925,229,441.30	53,311,669,685.57
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,925,229,441.30	53,311,669,685.57
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	1,462,972,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,462,972,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,462,972,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,296,420,298.19	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,296,420,298.19	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,296,420,298.19	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,296,420,298.19	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,296,420,298.19	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	35,628,809,143.11	54,774,641,685.57
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(35,628,809,143.11)	(39,486,895,951.09)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35,628,809,143.11	39,486,895,951.09
230001	Эргэж төлөгдөх зээл	35,628,809,143.11	39,486,895,951.09
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	15,287,745,734.48
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	15,287,745,734.48

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	251,077,416,131.20	251,077,416,131.20
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	251,077,416,131.20	251,077,416,131.20
3	Тайлант үеийн үр дүн	-	-	3,792,237,079.65	3,792,237,079.65
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	254,869,653,210.85	254,869,653,210.85
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(4,302,677,334.09)	(4,302,677,334.09)
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	250,566,975,876.76	250,566,975,876.76
7	Тайлант үеийн үр дүн	-	-	1,503,223,474.02	1,503,223,474.02
8	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	252,070,199,350.78	252,070,199,350.78

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	52,206,700,000.00	39,486,895,951.09	(12,719,804,048.91)	75.6
УРСГАЛ ЗАРДАЛ	2,368,700,000.00	-	(2,368,700,000.00)	-
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,368,700,000.00	-	(2,368,700,000.00)	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,368,700,000.00	-	(2,368,700,000.00)	-
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,368,700,000.00	-	(2,368,700,000.00)	-
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	49,838,000,000.00	39,486,895,951.09	(10,351,104,048.91)	79.2
Эргэж төлөгдөх зээл	49,838,000,000.00	39,486,895,951.09	(10,351,104,048.91)	79.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,206,700,000.00	54,774,641,685.57	2,567,941,685.57	104.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,368,700,000.00	1,462,972,000.00	(905,728,000.00)	61.8
Улсын төсвөөс санхүүжих	2,368,700,000.00	1,462,972,000.00	(905,728,000.00)	61.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,000,000,000.00	53,311,669,685.57	3,311,669,685.57	106.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000,000.00	53,311,669,685.57	3,311,669,685.57	106.6
БУСАД ЭХ ҮҮСВЭР	(162,000,000.00)	-	162,000,000.00	-
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(162,000,000.00)	-	162,000,000.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	15,287,745,734.48	15,287,745,734.48	

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 21,945.5 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг санхүүгийн тайланд 21,933.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 2.3 сая төгрөгийн залруулаагүй алдаанд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	Арилжааны банкнаас авах авлагын эргэн төлөлтөд хураан авсан 21,911.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн.	1	21,911,805.1			1	21,911,805.1	1	21,911,805.1				
	Авлагын дансанд 9 зээлдэгчийн 19.8 сая төгрөгийн шууд зээлийн, 1.4 сая төгрөгийн хувь хүмүүсээс авах, 2 зээлдэгчийн 0.1 сая төгрөгийн алдангийн авлагыг тус тус урьдчилж төлсөн орлогыг хасах үлдэгдлээр тайлагнасан.	1	21,342.3			1	21,342.3	1	21,342.3				
Жижиг, дунд үйлдвэрийн газар	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 4 нэр төрлийн 2.3 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд ангилал буруу бүртгэсэн.	1	2,321.0			1	2,321.0			1	2,321.0	1	2,321.0
Дүн		3	21,935,468.4	-	-	3	21,935,468.4	2	21,933,147.4	1	2,321.0	-	2,321.0

3.2 Аудитаар нийт 31,198.3 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс, 31,196.0 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 2.3 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 50,000.0 сая төгрөгийн зээлийг санхүүжүүлэхээс 38,606.5 сая төгрөгийн зээлийг 280 төсөлд олгосон нь төлөвлөснөөс 11,393.5 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байна.	1	11,393,457.8			1	11,393,457.8						
	Шууд зээлийн 134 зээлдэгчийн 19,442.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	19,442,020.2			1	19,442,020.2						
	Тайлант оны эцэст шууд зээлийн авлагын 96,500.7 сая төгрөгийн 360 зээлдэгчээс авах авлага "муу зээл"-ийн ангилалд бүртгэлтэй байна. Нийт муу зээлийн үлдэгдлийн 155 зээлдэгчийн 60,345.9 сая төгрөгийн зээлийн талаар шүүхийн шийдвэр гарсан байна.	1	-			1	-						
	Зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой 21,911.8 сая төгрөгийн хөрөнгийг эргэлтэд оруулаагүй ашиглалтын нэмэлт зардал гарч байна.	1	-					1	-				

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	Жижиг дунд үйлдвэрийн газрын даргын 2024 оны А/15 болон А/232 дугаар тушаалаар фискус зээлийн программ болон санхүүгийн бүртгэлийн программын хооронд зөрүүтэй бүртгэгдсэн зээлдэгчийн авлагын үлдэгдлийг санхүүгийн программд тохируулсан боловч нарийвчилсан тооцоолол хийж, зээлдэгч тус бүрээр акт үйлдээгүй нотлох баримт хангалтгүй байна.	1	-			1	-						
	Бараа материалын дэлгэрэнгүй тайланд зарим хөрөнгийн нэр, байршил, хэмжээ, бүртгэлийн дугаар, нэгж талбарын дугаарыг бичээгүй, ижил нэршлээр тодорхой бус бүртгэсэн, хөрөнгүүдийн хэмжих нэгжийг ширхгээр, бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан байна.	1	-					1	-				
Жижиг, дунд үйлдвэрийн газар	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас гадаад томилолтын зардалд 304.6 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	304,639.2			1	304,639.2						
	Автомашинь засвар үйлчилгээ хийхдээ техник хяналтын акт үйлдээгүй байна.	1	-					1	-				
	ТШЗ-ын санхүүгийн тайланд 37.5 сая төгрөгийн НДШ-ийн өглөг, 18.4 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөг бүртгэлтэй байна.	1	55,852.2			1	55,852.2						
	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 4 нэр төрлийн 2.3 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд ангилал буруу бүртгэсэн.	1	2,321.0						1	2,321.0			
Дүн	10	31,198,290.4	-	-	6	31,195,969.4	4	2,321.0	-	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

Нийцлийн асуудлаар нийт 1,832.4 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлж, түүнд ,1,832.4 сая төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	Шилэн дансны цахим хуудсанд 152 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт оруулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 1,762.4 сая төгрөгийн 38 орлогын, 70.0 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	1	1,832,408.2			1	1,832,408.2
Жижиг, дунд үйлдвэрийн газар	Шилэн дансны цахим хуудсанд 189 мэдээлэл оруулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-			1	-
Дүн		2	1,832,408.2	-	-	2	1,832,408.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	Борлуулах зорилготой бараа материалын дансанд бүртгэлтэй Лексус 570 /9163 УББ/, Toyota Prius 41 /1066 УЕТ/ маркийн автомашиныг эрх бүхий байгууллагын тогтоол, тушаал шийдвэргүйгээр байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна.	1	-			1	-
Дүн		1	-	-	-	1	-
Нийт дүн		3	1,832,408.2	-	-	3	1,832,408.2